

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэдэн-Иш	Дугаар	L283
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Мөрөн сум
Төрсөн газар	Мөрөн сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жилжигийн дуган	Сүм хийдийн дугаар	ХӨМХ 041
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Жилжигийн дуган

Мөнхбат: Тэгэхээр Цэдэн-Иш гуайгаас эхлээд энэ Жилжигийн хурал ер нь хэдий үед байгуулагдсан юм бол, ер нь баримжаагаар одоо багш нараасаа, өвөг дээдсээсээ сонссон тэр он цаг одоо байна уу?

Цэдийш. За энэ нэлээн дээхнэ үе гэж ярьдаг юм байна лээ, гучин, хорин найман онд л ерөнхийдөө энэ тарсан юм уу даа гэж манай эцэг эд нар ярьдаг юм байсан. Энэ одоо дагжуур гэдэг юм, дагжуур гэж энэ одоо энэ энүүхэн энэ тэртээ Мөрөнгийнхөө голоо гараад Хар усны дагуу энэ хоёр хүрээ байсан гэж манай багш айлддаг юм. Багш надад одоо очиж зааж өгсөн л дөө. Яг энэ байгаа юм аа гэж.

Мөнхбат: Хоёр дуган?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэдийш: Хоёр дуган байсан гэж. За энийг болвол юунд Арын хүрээ гэсэн юм гэхлээр зэрэг энэ Арын хүрээ гэдэг чинь энэ Далай гүний хошуунаа Халиугчин, Ар тогоруутан гэж нэрлэх ч байсан. 1933 онд энэ хоёр баг энэ Мөрөн сум гэж байгуулагдахад л наашаа ирж ирсэн гэж ярьдаг юм гэнэ лээ. Энд бол ийм хоёр хүрээ л байсан. Аа Жилжигт бол хүрээ байгаагүй. Энүүхэн энэ Дагжуур гэдэг юм. Энд байсан. Аа тэр Дуганчийн хүрээ гэж одоо тэр Тэлээгийн ам...

Мөнхбат: Аа тийм, тэд нарыг бид яваад яасан...

Данзанчойен: Тийм, тэнд одоо...

Мөнхбат: Дуганы булан гэдэг газар?

Данзанчойен: Тийм, тэнд одоо Тэлээгийн аманд бий.

Мөнхбат: Хөвсгөл аймгийн Галт сумын нутаг.

Данзанчойен: Үгүй ээ, Дуганы булан бүр цаашаагаа. Наашаагаа Төмөрбулагтаа бий. Тэнд хоёр хүрээ байсан, нэг нь буулгагдсан. Дуганы хүрээ гэж одоо тэр урд талдаа, ийшээгээ зүүн талдаа, зүүн хойд талдаа ч гэдэг юм уу нэг овоотой.

Мөнхбат: Тэгэхээр одоо Жилжигийн хурал гэж энэ дэр тэмдэглэгдсэн энэ нэр томъёо бол одоо тэгэхээр тэр дуган байсан газартай харьцуулахад бол одоо буруу гэж ойлгож байна, одоо миний ойлголтоор бол.

Данзанчойен: Тийм.

Мөнхбат: Тэгэхээр та одоо газрынх нь нэрийг дахин тодруулж хэл дээ?

Данзанчойен: Тэгэхээр энэ жасын дэнж гэдэг байсан юм.

Мөнхбат: Жас?

Данзанчойен: Жас, жасын дэнж.

Мөнхбат: Тэр жасын дэнжийн ойролцоо ер нь жилжиг гэдэг нэртэй газар байна уу?

Данзанчойен: Аа ийшээ байна, энэ урд тал руу. Энэ Эрчлээг уруудаад доод тал руу.

Мөнхбат: За тэр хоёр, тэр жасын дэнж буюу тэр дуганы туурь байгаа тэр жасын дэнжээс тэр жилжиг гэдэг нэртэй газар хүртэл нэлээн зайтай болж байна, тийм ээ?

Данзанчойен: Өө эндээс яахав дээ, энэ...

Мөнхбат: Хоорондоо?

Данзанчойен: Хоорондоо болвол нэг хориодхон км-ийн зай л байна.

Мөнхбат: Тэгэхээр хориод км гэдэг чинь бас, монголчууд чинь бас дов болгон нэртэй, тийм ээ?

Данзанчойен: Тийм.

Мөнхбат: Ус болгон домогтой байдаг. Тэгэхээр тэгж бол андуурч бичнэ гэж бол болохгүй тийм ээ?

Данзанчойен: Тийм, тэр бол байхгүй.

Мөнхбат: Ер нь бол байгаа газраар нь нэрлэвэл яах аргагүй л жасын дэнж гэж нэрлэх нь зүйтэй юм байна тийм ээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Данзанчойен: Тийм, жасын дэнж.

Мөнхбат: За тэгэхээр Цэдэн иш гуай, бас их үнэтэй сонирхолтой мэдээлэл өгсөнд баярлалаа. Тэгэхээр жасын дэнж дээр байсан энэ хоёр дуган маань одоо ямар хэдэн лам суудаг байсан юм бол, ямар ямар хурал хурдаг байсан юм бол...?

Данзанчойен: За ямар чиг байсан энэ нөгөө цогчин хурлаа айлдаад, тэгээд тэр сахиусныхаа одоо ямар юу нь байдгийн. Энэ чинь жар гаруй ламтай байсан гэж айлддаг юм байна лээ. Манай аав, манай багш энэ тэр л тэгдэг байсан, жараад ламтай байсан юм гэж.

Мөнхбат: Яг одоо сахиус шүтээнийх нь талаар та одоо?

Данзанчойен: Би одоо тэрийг мэдэхгүй байна. Би бодоход одоо энэ юуныхаа Далай гүний хошуундаа харьяалагдаж байсан болохлээр энэ одоо өнөөх дамдин чойжоотойгоо холбоотой байсан болов уу л гэж би дотроо бодож таадаг юм.

Мөнхбат: Тэгэхээр энэ дуганы туурийн талаар, дуганы одоо үлдсэн туурь, ул мөр өнөөдөр ер нь ямар хэмжээнд байна вэ?

Данзанчойен: Яг л одоо тэр байгаа орчныхоо л тэр хоёр дуганы ор бий, тэр жасын дэнж одоо. Тэр мод энэ тэр байхгүй, одоо яахав тэгээд засчихсан.

Мөнхбат: Газрын гадарганд одоо бараг бүрэн идэгдчихсэн?

Данзанчойен: Тийм, идэгдчихсэн. Одоо тийм л хад мадаар дугуйлчихсан, тиймэрхүү л байдаг юм.

Мөнхбат: Хэмжээг нь одоо барагцаалж хэлбэл?

Данзанчойен: За хэмжээ нь одоо явахад ямар чиг байсан, хааш хаашаагаа нэг, нэг нь ер нь багцаалахад зургаа наймын харьцаатай болов уу гэж би нэг алхаж үзсэн юм. Ер нь ямархуу хэмжээтэй юм, гэхдээ миний тэр алхалт болвол алдаж гишгээ л байх л даа. Тийм л юм.

Мөнхбат: За баярлалаа, таньд. Ингээд манай судалгааны баг энэ удаа энэ нэгэнт одоо бараг хоёр зуу шахам жилийн тэртээ үүсч байгуулагдаад мөхөөд одоо бараг далаад жил болж байгаа энэ дуганы одоо суурийг ингэж л одоо нүдэн баримжаагаар хүмүүсийн амаар ингэж тодруулахыг оролдсон юм аа. За ингээд Ренчин гүайн бүртгэл жагсаалтад Жилжигийн хүрээ хэмээн нэрлэгдсэн боловч орон нутгийнхны яриагаар жасын дэнж хэмээх газар байдаг энэ хоёр дуганы талаар үнэтэй мэдээлэл өгсөн таньд их баярлалаа.